


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 22 эдөр

Дугаар 22

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, сэлбэг хэрэгслээр
ашиглах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Мандалын гэгээ хот тохижуулах газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 26,611,395,74 (хорин зургаан сая зургаан зуун арван нэгэн мянга гурван зуун ерэн таван төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 14,192,744.46 (арван дөрвөн сая нэг зуун ерэн хоёр мянга долоон дөчин дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 52-71 ДУЭ улсын дугаартай Dongfeng CLW5070 маркийн автомашиныг сэлбэг хэрэгслээр эргэлтийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сэлбэг хэрэгслээр бүртгэгдэх CLW5070 маркийн автомашины кабиныг “Дундговь- Ус” ОНӨААТҮГ-т шилжүүлэн өгөхийг зөвшөөрсүгэй.

3. “Мандалын гэгээ хот тохижуулах газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Д.Очбадрах), “Дундговь-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (О.Бархүү) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1. Үндсэн хөрөнгө акталснаас гарсан материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

3.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн

тогтоолын хавсралт

“Мандалын гэгээ хот тохижуулах газар” Орон нутгийн өмчit аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
сэлбэг хэрэгслээр ашиглах тээврийн хэрэгслийн мэдээлэл



| д/д | Тээврийн хэрэгслийн төрөл | Mark | Улсын бүртгэлийн | | Тээврийн хэрэгслийн мэдээлэл | | Балансын үнэ | Хуимтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | |
|----------|---------------------------|------------------|------------------|-----------|------------------------------|--------------------|---|---|---|---------------|
| | | | с | е | р | и | | | | |
| 1 | Тусгай зориулалт | dongfeng CLW5070 | | 52-71 дүЭ | 2016 | L16264CT8G10 22147 | 2890 | 26,611,395.74 | 12,418,651.28 | 14,192,744.46 |
| Нийт дүн | | | | | | | | | | |
| | | | | | | | 14,192,744.46 (арван дөрвөн сая нэг зуун ерэн хоёр мянга долоон дөчин дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөг | 12,418,651.28 (арван хоёр сая дөрвөн зуун арван найман мянга зургаан зуун тавин нэгэн төгрөг хорин найман мөнгө) төгрөг | 14,192,744.46 (арван дөрвөн сая нэг зуун ерэн хоёр мянга долоон дөчин дөрвөн төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөг | |